



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГЫН ТӨСВИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:

Газрын дарга: С.Энхзаяа
Утас: 261663

Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512

Цахим хаяг:
oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор : Г.Юра
Утас: 263813

Цахим хаяг:
yurag@audit.gov.mn

Шинжээч : Д.Будмаа
Утас: 261740

Цахим хаяг:
budmaad@audit.gov.mn

Үндэсний Аудитын Газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол Улс

Цахим хуудас: www.audit.mn

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ
Хавсралт 2: Менежментийн захидал
Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан

2014 оны 4 дүгээр сар

Оршил

Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна. Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Ийнхүү хянахдаа байгууллагын дотоод хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Аудитаар дээд түвшний хяналтын асуудал хөндөгдсөн бөгөөд тэдгээрийг удирдлагын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Хүний эрхийн үндэсний комисс санхүүгийн үйл ажиллагаандаа санхүү, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийг ашигладаггүй, Excel програм дээр цалин хөлсний болон үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоолол, бараа материал, үндсэн хөрөнгийн орлого зарлагын хөдөлгөөн зэрэг санхүү, нягтлан бодох бүртгэлийн бүхий л тоон мэдээллийг гараар шивж оруулж байгаа нь нягтлан бодогчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж, арифметик санамсаргүй алдаа гарах эрсдэл өндөр, санхүүгийн тайлан, тодруулгуудыг Сангийн яамны Төрийн санд нэгтгэхэд хүндрэл учруулах зэрэг олон сөрөг үр дагавртай байна.
- Тус байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.2 дугаар заалтад “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

- Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ”-г зөрчин компьютер, мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, суудлын автомашин, хөргөгч зэрэг үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг илүү тогтоож, улмаар хуримтлагдсан элэгдлийг дутуу дүнгээр тооцоход хүргэсэн байна. Үүнд:

Хөрөнгийн ашиглалтын жил

	<u>Тооцвол зохих</u>	<u>Тооцсон</u>
• компьютер зэрэг мэдээлэл технологийн тоног төхөөрөмж	5	4
• суудлын автомашин	6	10
• хөргөгч	4	5

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын санал дүгнэлт

Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улсынбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 686

таний _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Хүний эрхийн үндэсний комиссын удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР  А. ЗАНГАД

078453



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГЫН ТӨСВИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

Асуудал 1

Санхүүгийн тооцоолох програмын талаар

Асуудал 2

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Асуудал 3

Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг. Түүнд дотоод хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Хүний эрхийн үндэсний комиссын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хүний эрхийн үндэсний комиссын нягтлан бодогч С.Нармандах болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

- Цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлууд;
- Удирдлагын анхаарах шаардлагатай асуудлууд;

Асуудал 1 Санхүүгийн програмын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Хүний эрхийн үндэсний комисс санхүүгийн үйл ажиллагаандаа санхүү, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийг ашигладаггүй, Excel програм дээр цалин хөлсний болон үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоолол, бараа материал, үндсэн хөрөнгийн орлого зарлагын хөдөлгөөн зэрэг санхүү, нягтлан бодох бүртгэлийн бүхий л тоон мэдээллийг гараар шивж оруулж байгаа нь нягтлан бодогчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж, арифметик санамсаргүй алдаа гарах эрсдэл өндөр, санхүүгийн тайлан, тодруулгуудыг Сангийн яамны Төрийн санд нэгтгэхэд хүндрэл учруулах зэрэг олон сөрөг үр дагавртай байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд зарим тоон мэдээллүүдийг орхигдуулах, буруу зөрүү тусгаснаар төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлан тэнцэл, тодруулга буруу илэрхийлэгдэх.

ҮАГ-ын зөвлөмж

Санхүү, нягтлан бодох бүртгэл тооцооллын програм хангамжтай болох асуудлыг судлан шийдвэрлэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.2 дугаар заалтад “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлж, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах дотоод хяналт алдагдах.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ”-г зөрчин компьютер, мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, суудлын автомашин, хөргөгч зэрэг үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг илүү тогтоож, улмаар хуримтлагдсан элэгдлийг дутуу дүнгээр тооцоход хүргэсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ”-г баримтлан 2014 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийн залруулах бичилтийг хийх.

Зөвлөмжийн биелэлтийг 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдэл, санхүүгийн үр дүн буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд буруу ташаа мэдээлэл өгөх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u>	-	7,489,686.94
Кассад байгаа бэлэн мөнгө		
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	-	7,489,686.94
<u>АВЛАГА</u>	-	-
Бусад авлага		
<u>УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР</u>	-	-
Урьдчилж гарсан зардал		
<u>БАРАА МАТЕРИАЛ</u>	438,100.00	1,051,900.00
Хангамжийн материал	438,100.00	1,051,900.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	438,100.00	8,541,586.94
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
<u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u>	66,419,214.76	127,905,676.93
<u>Биет хөрөнгө</u>	66,419,214.76	127,905,676.93
Авто- тээврийн хэрэгсэл	-	62,884,704.00
Хуримтлагдсан элэгдэл	-	(9,432,705.60)
Машин, тоног төхөөрөмж	66,681,871.00	92,380,521.00
Хуримтлагдсан элэгдэл	(47,560,851.40)	(67,234,721.33)
Тавилга, аж ахуйн эд хогшил	99,159,229.00	107,134,629.00
Хуримтлагдсан элэгдэл	(72,633,094.85)	(78,742,511.15)
Номын фонд	20,772,061.01	20,915,761.01
<u>Биет бус хөрөнгө</u>	-	-
Програм хангамж	963,000.00	963,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(963,000.00)	(963,000.00)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	66,419,214.76	127,905,676.93
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	66,857,314.76	136,447,263.87
Өглөг	-	-
Ажиллагчидтай холбогдсон өглөг		
Урьдчилж орсон орлого	-	-
Бусад урьдчилж орсон орлого		
<u>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u>	-	-
Урт хугацаат зээл		
<u>УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</u>	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
Засгийн газрын капитал	88,356,515.61	88,356,515.61
Дахин үнэлгээний нөөц	8,900,164.00	8,900,164.00
Өмнөх үеийн үр дүн	(7,365,695.93)	(30,399,364.85)
Тайлант үеийн үр дүн	(23,033,668.92)	69,589,949.11
<u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</u>	66,857,314.76	136,447,263.87
<u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</u>	66,857,314.76	136,447,263.87

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Улсын төсвөөс	433,205,100.00	546,635,950.00
Урсгал	433,205,100.00	526,751,400.00
Хөрөнгийн		19,884,550.00
Нийгмийн даатгалын сангаас	33,000,933.00	
Бусад тусгай зориулалтын сангаас	33,000,933.00	
Урсгал тусламж /төсөл арга хэмжээ/		53,377,446.54
Хандив, тусламжийн орлого		67,823,815.27
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
Ангилалдаагүй орлого /Арилжааны банк дахь дансны/		1,662.42
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	466,206,033.00	667,838,874.23
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	269,560,714.33	342,990,510.06
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	242,732,169.82	309,625,610.78
Үндсэн цалин	228,731,114.82	292,084,898.78
Унаа болон бусад нөхөн олговор	14,001,055.00	17,540,712.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	26,828,544.51	33,364,899.28
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	21,951,115.12	27,299,160.59
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	17,096,471.12	21,232,680.46
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,213,661.00	2,426,592.05
ҮОМШ өвчний даатгал	2,427,322.00	3,033,240.07
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,213,661.00	606,648.01
Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,877,429.39	6,065,738.69
Бараа үйлчилгээний урсгал зардал	153,997,622.03	196,904,492.09
Бусад бараа үйлчилгээний зардал	153,997,622.03	196,904,492.09
Бичиг хэргийн материал	9,024,920.00	7,443,150.60
Тээвэр, шатахууны зардал	27,908,758.00	33,736,140.00
Шуудан холбооны зардал	9,978,369.14	11,257,950.90
Дотоод томилолтын зардал	10,712,500.00	23,059,425.00
Гадаад томилолтын зардал	18,310,137.91	22,164,342.42
Ном, хэвлэлийн зардал	20,972,000.00	17,205,000.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	29,526,559.40	28,957,209.60
Жижиг эд хогшил худалдан авах зардал	545,921.44	650,000.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	1,470,948.00	23,377,370.47
Урсгал засварын зардал	430,000.00	500,000.00
Гадаадын зочны зардал	9,022,369.20	2,188,300.00
Элэгдлийн зардал	16,095,138.94	26,365,603.10
Хөтөлбөр арга хэмжээний зардал	36,819,819.60	-
Гадаадын эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа	32,950,933.00	
Он дамжсан төсөл арга, хэмжээ	3,868,886.60	
Тусламж, шилжүүлэг	10,268,105.96	14,538,982.97

Олон улсын байгууллагын гишүүний татвар	4,039,280.00	11,876,860.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	6,228,825.96	2,662,122.97
Засгийн газрын нөөц хөрөнгө		
Нийгмийн хамгааллын зардал	6,350,000.00	28,077,626.00
Нэг удаагийн тэтгэмж		13,690,333.00
Нэг удаагийн буцалтгүй тусламж	3,750,000.00	850,000.00
Шагнал, урамшуулал	2,600,000.00	13,537,293.00
Бусад зардал	12,243,440.00	15,737,314.00
Байрны түрээсийн зардал	12,243,440.00	15,737,314.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	489,239,701.92	598,248,925.12
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(23,033,668.92)	69,589,949.11
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
Үндсэн хөрөнгө худалдсаны олз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
Хөрөнгө худалдсаны гарз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(23,033,668.92)	69,589,949.11

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	466,574,411.56	600,013,396.54
Олон улсын байгууллагын тусламж	33,000,933.00	53,377,446.54
Урсгал тусламж	33,000,933.00	53,377,446.54
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	433,573,478.56	546,635,950.00
Улсын төвлөрсөн төсвөөс	433,573,478.56	546,635,950.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	433,573,478.56	526,751,400.00
Хөрөнгийн санхүүжилт		19,884,550.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,662.42
Татварын бус бусад орлого	-	1,662.42
Ангилалдаагүй орлого /Арилжааны банк дахь дансны/	-	1,662.42
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	466,574,411.56	600,015,058.96
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	269,560,714.33	342,990,510.06
Үндсэн болон нэмэгдэл цалин	242,732,169.82	309,625,610.78
Үндсэн цалин	228,731,114.82	292,084,898.78
Унаа болон бусад нөхөн олговор	14,001,055.00	17,540,712.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	26,828,544.51	33,364,899.28
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	21,951,115.12	27,299,160.59
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	17,096,471.12	21,232,680.46
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,213,661.00	2,426,592.05
ҮОМШ өвчний даатгал	2,427,322.00	3,033,240.07
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,213,661.00	606,648.01
Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,877,429.39	6,065,738.69
Бараа, үйлчилгээний урсгал зардал	148,394,201.65	186,890,002.99
Бусад бараа үйлчилгээний зардал	148,394,201.65	186,890,002.99
Бичиг хэргийн материал	7,769,420.00	8,056,950.60
Тээвэр, шатахууны зардал	27,908,758.00	33,736,140.00
Шуудан холбооны зардал	9,978,369.14	11,257,950.90
Дотоод томилолтын зардал	10,712,500.00	23,059,425.00
Гадаад томилолтын зардал	18,310,137.91	24,438,182.42
Ном, хэвлэлийн зардал	20,501,200.00	19,002,820.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага, сургуулилт	29,526,559.40	24,885,549.60
Жижиг эд хогшил худалдан авах зардал	520,500.00	650,000.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	1,470,948.00	23,377,370.47
Урсгал засварын зардал	430,000.00	500,000.00
Гадаадын зочны зардал	9,022,369.20	2,188,300.00
Байрны түрээсийн зардал	12,243,440.00	15,737,314.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	36,819,819.60	-
Хөтөлбөр төсөл, сан, арга хэмжээний зардал	36,819,819.60	-

Гадаадын эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа	32,950,933.00	
Он дамжсан төсөл арга, хэмжээ	3,868,886.60	
ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ	10,268,105.96	14,538,982.97
Олон улсын байгууллагуудад	4,039,280.00	11,876,860.00
Олон улсын гишүүний татвар, хандив	4,039,280.00	11,876,860.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	6,228,825.96	2,662,122.97
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	6,350,000.00	28,077,626.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	6,350,000.00	28,077,626.00
Нэг удаагийн тэтгэмж		13,690,333.00
Нэг удаагийн буцалтгүй тусламж	3,750,000.00	850,000.00
Шагнал урамшил	2,600,000.00	13,537,293.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	471,392,841.54	572,497,122.02
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(4,818,429.98)	27,517,936.94
Хөрөнгийн орлого	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	864,600.00	20,028,250.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	864,600.00	20,028,250.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(864,600.00)	20,028,250.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)=(III)+(VI)	(5,683,029.98)	7,489,686.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,683,029.98	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	7,489,686.94

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2011 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	90,265,517.61	8,900,164.00	(7,365,695.93)	91,799,985.68
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	90,265,517.61	8,900,164.00	(7,365,695.93)	91,799,985.68
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(23,033,668.92)	(23,033,668.92)
Үндсэн хөрөнгийн өсөлт/ +/, бууралт /-/	(1,909,002.00)			(1,909,002.00)
2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	88,356,515.61	8,900,164.00	(30,399,364.85)	66,857,314.76
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,356,515.61	8,900,164.00	(30,399,364.85)	66,857,314.76
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			69,589,949.11	69,589,949.11
Үндсэн хөрөнгийн өсөлт				-
2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	88,356,515.61	8,900,164.00	39,190,584.26	136,447,263.87

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	546,635,950.00	543,973,827.03	2,662,122.97	99.5
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	546,635,950.00	543,973,827.03	2,662,122.97	99.5
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	526,751,400.00	524,089,277.03	2,662,122.97	99.5
Бараа ажил үйлчилгээний зардал	526,751,400.00	524,089,277.03	2,662,122.97	99.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,317,000.00	303,238,360.78	78,639.22	100.0
Үндсэн цалин	279,504,200.00	285,697,648.78	(6,193,448.78)	102.2
Унаа, болон бусад нөхөн олговор	23,812,800.00	17,540,712.00	6,272,088.00	73.7
Нийгмийн хамгааллын шимтгэл	33,364,900.00	33,364,899.28	0.72	100.0
Тэтгэврийн даатгал	21,232,166.67	21,232,680.46	(513.79)	100.0
Тэтгэмжийн даатгал	2,426,533.33	2,426,592.05	(58.72)	100.0
ҮОМШ өвчний даатгал	3,033,166.67	3,033,240.07	(73.40)	100.0
Ажилгүйдлын даатгал	606,633.33	606,648.01	(14.68)	100.0
Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	6,066,400.00	6,065,738.69	661.31	100.0
Бараа, үйлчилгээний бусад зардал	190,069,500.00	187,486,016.97	2,583,483.03	98.6
Бичиг хэрэг	6,885,000.00	7,546,950.60	(661,950.60)	109.6
Тээвэр (шатахуун)	29,327,200.00	28,652,140.00	675,060.00	97.7
Шуудан холбоо	11,136,200.00	11,257,950.90	(121,750.90)	101.1
Дотоод албан томилолт	12,020,000.00	14,115,925.00	(2,095,925.00)	117.4
Гадаад томилолт арга хэмжээ	18,627,800.00	19,146,520.00	(518,720.00)	102.8
Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.0
Төлбөр хураамж бусад зардал	9,568,500.00	20,507,370.47	(10,938,870.47)	214.3
Ном хэвлэл авах	18,583,100.00	17,348,700.00	1,234,400.00	93.4
Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\	650,000.00	650,000.00	-	100.0
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийх	21,500,000.00	21,420,360.00	79,640.00	99.6
Гадаад зочны зардал	6,000,000.00	2,188,300.00	3,811,700.00	36.5
Олон улсын гишүүний татвар	1,888,800.00	11,876,860.00	11,940.00	99.9
Тээврийн хэрэгслийн даатгал	500,000.00	-	500,000.00	-
Байрны түрээсийн зардал	15,744,900.00	15,737,314.00	7,586.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	800,000.00	850,000.00	(50,000.00)	106.3
Шагнал, урамшууллын зардал	2,000,000.00	1,997,293.00	2,707.00	99.9
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,258,000.00	13,690,333.00	10,567,667.00	56.4
Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	-	80,000.00	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	-
IV. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,884,550.00	19,884,550.00	-	100.0
1. Дотоод хөрөнгө оруулалт	-	-	-	-
Төсвийн хөрөнгөөр санхүүжих их засвар	-	-	-	-
Төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж	19,884,550.00	19,884,550.00	-	100.0
Өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт	-	-	-	-
V. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-
VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:	546,635,950.00	543,973,827.03	2,662,122.97	99.5
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-	-	-

Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих			-	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-	
Төрийн сургалтын сангаас санхүүжих			-	
Татварын бус бусад орлого			-	
Төсвөөс санхүүжих	546,635,950.00	543,973,827.03	2,662,122.97	99.5
Урсгал санхүүжилт	526,751,400.00	524,089,277.03	2,662,122.97	99.5
Хөрөнгө оруулалт	19,884,550.00	19,884,550.00	-	100.0
Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл	-	-	-	-
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл /Нэмэлт санхүүжилтийн/		7,489,686.94	-	
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		50,716,985.99		
Байгууллагын тоо	1	1	-	-
Ажиллагсад бүгд	28	27	1	96.4
Удирдах ажилтан	4	4	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	21	20	1	95.2
Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0
Гэрээт ажилтан	0	0	-	